

**ГАЛТ ЗЭВСГИЙН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ
ГЭМТ ХЭРЭГТ ОНОГДУУЛАХ ЯЛ, ОНЦЛОГ
PUNISHMENT AND CHARACTERISTICS OF CRIMES
RELATED TO ILLEGAL TRAFFIC OF FIREARMS**

Ц.Очгэрэл

ДХИС-ийн докторант, цагдаагийн хурандаа

Товч агуулга: Эрдэм шинжилгээний өгүүлэлд галт зэвсгийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт оногдуулах ялын ойлголт, түүний онцлогийг нээн гаргав.

Түлхүүр үг: галт зэвсгийн хууль бус эргэлт, хууль зүйн хариуцлага, эрх зүйн позитив буюу эергүү хариуцлага, эрх зүйн негатив буюу сөргүү хариуцлага, эрүүгийн хариуцлага, торгох ял, зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ял.

Галт зэвсгийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт оногдуулах ялын тухай асуудлыг хөндөхийн өмнө хууль зүйн хариуцлагын ойлголтыг авч үзэх шаардлагатай гэж бид үзэв. Хууль зүйн хариуцлага нь эрх зүйн мөн чанар, түүний чиг үүрэг, зарчим, нийгмийн зорилгыг илүү тодорхой илэрхийлнэ. Хууль зүйн хариуцлага гэсэн ойлголт нь олон талт, нарийн төвөгтэй байдлаараа эрх зүйн зөрчил, эрх зүйн хэм хэмжээ, төрийн албадлага, эрх зүйн харилцаа, эрх зүйн хэрэглээ, эрх зүйн зан үйлтэй илүү нягт холбоотойгоор тайлбарлагдах бөгөөд энэ шинж нь өнөө цагийн Монгол Улсад эрх зүйн онол болон хууль зүйн шинжлэх ухааны хоёр хандлагыг тодорхойлж байна.

Эхний хандлагыг баримтлагчид нь хууль зүйн хариуцлагыг эрх зүйн зөрчлийн шууд үр дагавар гэж үздэг бол, нөгөө нэг хэсэг нь түүнийг эрх зүйн хариуцлагатай холбож үзэх төдийгүй, мөн ирээдүйн үйл ажилтай холбон үзэж байна¹.

Эрх зүйн негатив буюу сөргүү хариуцлага нь санкцын хэрэгжилт; төрийн албадлагын арга хэмжээ; ял (шийтгэл); эрх зүйн зөрчилд нийгмээс үзүүлэх хариу үйлдэл, эрх зүйн зөрчлөөс урган гарсан хууль зүйн үүрэг,

¹ Нямсүрэн, Ч. Эрх зүйн ерөнхий онол. -УБ., 2021. 370 дахь тал.

өөрийн зан үйлийн төлөө хүлээж буй үүрэг; албадлагын нөлөөллийн арга хэмжээг хүлээх чадвар; нийгэмд аюултай үзэгдэлд өгөх үнэлэмж болон түүнийг үйлдсэн этгээдийг буруутгах хэлбэр гэж ойлгож байна.

Мөн эергүү буюу позитив хариуцлагыг авч үзэх өөр хандлага бас бий. Энэ хариуцлагыг үүргийн ухамсар, үүргийн мэдрэмж, хууль зүйн дагуу үйл ажиллагаа явуулах үүрэг болон тухайн үүргийн хэрэгжилт, мөн түүнчлэн урамшууллын арга хэмжээг хэрэглэх нөхцөл гэж ойлгож байна¹.

Эрүүгийн хариуцлага нь хууль зүйн хариуцлагын нэг төрөл юм. Монголын эрүүгийн эрх зүйн мэргэжилтэн, судлаачид хууль зүйн хариуцлага, түүний дотор эрүүгийн хариуцлага гэж юу болох талаар дээр дурдсаны дагуу хоёр өөр хандлагыг баримталж байна.

Дээрх хандлагуудтай холбоотойгоор эрүүгийн хариуцлагыг ялтай адилтгаж үзэх, эсвэл эдгээр нь хоёр өөр зүйл гэж үзэх байр суурь зонхилж байна.

Проф. Г.Совд эрүүгийн хариуцлагыг «төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх олон талт ажиллагааны хамгийн хүнд, тусгай арга хэмжээ, тодорхой субъектын хувьд эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ зөрчсөний үр дагавар болгон эрхийн байдалд нь урт хугацаагаар нийгмээс тусгаарлах, түүгээр ч барахгүй амьд явах эрхэнд нь халдах хүртэл хязгаарлалт тогтоож байгаа явдал»² гэж тодорхойлсон нь үндсэндээ эрүүгийн хариуцлагыг ялтай адилтган үзсэн гэсэн үг юм.

Проф. С.Жанцан эрүүгийн хариуцлагыг «гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдэд эрүүгийн хуулийн хэм хэмжээг хэрэглэсний үр дүн, эрх зүйн үр дагавар гэж явцуу утгаар тодорхойлж болох юм»³ гэж үзсэн нь дээрх байр суурьтай ижил байгааг харуулж байна.

Харин акад. С.Нарангэрэл эрүүгийн хариуцлагыг «гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдсэн хэргээ эрүүгийн хуулийн дагуу хариуцах үүрэг, түүний бодит хэрэгжилт» гэж үзсэн нь анхаарал татаж байна.

¹ Мөн тэнд. 371 дэх тал.

² Совд, Г. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. -УБ., 2002. 59 дэх тал.

³ Жанцан, С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол (Ялын тухай сургаал). II боть. -УБ., 2004. 104 дэх тал.

Акад. С.Нарангэрэл, проф. Ж.Эрдэнэбулган нар ¹ эрүүгийн хариуцлагын онцлог шинжийг дараах байдлаар тоймлож үзсэн байна:

1) Эрүүгийн хариуцлага нь юуны өмнө үйлдсэн гэмт хэргээ хариуцах тухайн этгээдийн хүлээх үүрэг бөгөөд энэ үүргийн хэрэгжилтийг төр, тусгай (хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүх зэрэг) байгууллагаараа дамжуулан хангана. Гэмт хэрэг илрээгүй байсан ч гэмт хэрэг үйлдсэн үеэс эхлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх хөөн хэлэлцэх хугацаа үйлчилнэ.

2) Эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх асуудал нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой хэлбэрийн журамлал (процедур)-ыг буй болгож хэрэглэхийг шаардана.

3) Эрүүгийн хариуцлагын агуулга нь гэм буруутай этгээдийг үйлдсэн гэмт хэрэгт нь буруутгаж, түүний эрх, эрх чөлөөнд албадан хязгаарлалт тогтооход оршино. Энэ нь юуны өмнө үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан таслан сэргийлэх албадлагын арга хэмжээ (хувийн баталгаа гаргах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэх, түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, барьцаа авах, цагдан хорих зэрэг) авах, дуудан ирүүлэх, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах зэргээр илэрнэ. Хэрэв шүүх ял ногдуулбал ял шийтгүүлэгч ногдуулсан ялын агуулга болсон эрх, эрх чөлөөнд тогтоосон хязгаарлалтыг амсаж, түүнийг даван туулах зайлшгүй шаардлагыг үүсгэнэ.

4) Эрүүгийн хэрэгт холбогдсон этгээдийн үйлдсэн үйл, гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй болох нь тогтоогдвол эрүүгийн хариуцлага нь ял ногдуулахгүй байх (эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх) болон ял ногдуулах хоёр хэлбэрийн аль нэгээр бодитой хэрэгжинэ.

5) Ял ногдуулсан тохиолдолд ял эдэлж ялтай хугацаа дууссаны дараа эрүүгийн хариуцлагын асуудал сая эцэслэгдэнэ.

6) Эрүүгийн хариуцлага нь нийгмийн шударга ёсыг тогтоох, гэмт халдлагаас хамгаалах, шинээр гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх нэн чухал хэрэглүүр болно.

¹ Нарангэрэл, С., Эрдэнэбулган, Ж. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж

(Нэгэн сэдэвт бүтээл). -Уб., 2019. 30 дахь тал.

Монгол Улсын Эрүүгийн хуульд (2015) эрүүгийн хариуцлага ба ялын ялгааг нарийвчлан тусгаж чадаагүйгээс улбаалж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг Эрүүгийн хуульд зөв томъёолж чадахгүй болж, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх институтыг цуцлахад хүргэсэн байдаг¹.

Гадаад орны эрүүгийн эрх зүйн ном бүтээлүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд эрүүгийн хариуцлагын агуулга, мөн чанар чухам юу болох талаар эрдэмтэн, судлаачдын байр суурь зөвхөн дээр дурдсан хоёр хандлага, тухайлбал, 1) эрүүгийн хариуцлага ял шийтгэл хоёр ижил агуулгатай; 2) эрүүгийн хариуцлага нь үйлдсэн хэргээ хариуцах тухайн этгээдийн үүрэг; зэргийг оруулаад өөр хэд хэдэн үзэл баримтлал байгаа болох нь бидний судалгаанаас тодорхой боллоо. Эдгээр нь:

- эрүүгийн хариуцлага ял шийтгэл хоёр ижил агуулгатай;
- эрүүгийн хариуцлага нь үйлдсэн хэргээ хариуцах тухайн этгээдийн үүрэг;
- эрүүгийн хариуцлага нь ял шийтгэлтэй холбоотой цээрлэлийг үүрэх үүрэг
- эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэний улмаас түүнд оногдуулсан шийтгэлтэй холбоотой эрх зүйн байдал
- эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэгтэнд төрийн нэрийн өмнөөс шүүхийн яллах тогтоолоор хүлээлгэж буй гэсгээл
- эрүүгийн хариуцлага нь эрүүгийн эрх зүйн харилцаа мөн бөгөөд талууд нь нэг талаас төр, нөгөө талаас гэмт хэрэг үйлдсэн этгээд байна.

Эдгээр үзэл баримтлал, хандлагуудтай холбоотойгоор проф. А.И.Рарор эрүүгийн хариуцлагыг «энэ нь гэмт хэрэг үйлдсэний төлөө, үйлдсэн хэргээ хүлээж шүүхийн өмнө зогсох гэмт этгээдийн үүрэг, гэмт этгээдийг болон түүний гэмт үйлдлийг шүүхийн тогтоолоор төрийн нэрийн өмнөөс буруутгах гэсгээл, оногдуулсан ял болон эрүүгийн эрх зүйн албадлагын бусад арга хэмжээ, түүнчлэн ялтай байдал зэрэг хэд хэдэн элемент, бүрдэл хэсгээс үүссэн иж бүрэн ойлголт мөн юм»² гэж тодорхойлсонтой бид санал нэгдэж байна.

¹ Мөн тэнд. 31 дэх тал.

² Уголовное право России. Части Общая и Особенная: учебник (Под ред. А. И. Рарога). - М., 2008. С. 47.

Дээрх тодорхойлолтоос үзэхэд «эрүүгийн хариуцлага» гэх ухагдахуун нь ял (шийтгэл) гэсэн ухагдахуунаас илүү өргөн хүрээтэй, нэг нь нөгөөгөө агуулгадаа багтаасан өргөн хүрээтэй, иж бүрэн ойлголт мөн болохыг бид харж байна.

Харин ял (шийтгэл) бол шүүхийн тогтоолоор томилж буй төрийн албадлагын арга хэмжээ мөн юм. Гэмт хэрэг үйлдсэн буруутай болох нь тогтоогдсон этгээдэд ялыг хэрэглэх ба энэ нь тухайн этгээдэд Эрүүгийн хуульд тусгасан эрх, эрх чөлөөг нь хасах, хязгаарлах байдлаар хэрэгжинэ. Нийгмийн шударга ёсыг сэргээн тогтоох, гэмт этгээдийг засан хүмүүжүүлэх, шинэ гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ялыг хэрэглэнэ.

Ял нь дараах үндсэн шинжтэй:

- 1) Ял нь эрүүгийн хуулиор тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ;
- 2) Ялыг төрийн нэрийн өмнөөс шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулна;
- 3) Ялыг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд (санаатай болон болгоомжгүйгээр гэмт хэрэг үйлдсэн) хэрэглэнэ;
- 4) Ялын мөн чанар нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх, эрх чөлөөг хуульд заасны дагуу хасах болон хязгаарлахад оршино;
- 5) Хуульд заасан журмын дагуу ялыг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх заалтад ялын зорилгыг тодорхойлсон бөгөөд энэ нь:

- Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх;
- Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх;
- Хохирлыг нөхөн төлүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;
- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин нийгэмшүүлэх явдал юм.

Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлийн 1 дэх заалтад ялын төрлийг заажээ. Үүнд:

1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд доор дурдсан ял оногдуулна:
 - 1.1. торгох ял;
 - 1.2. нийтэд тустай ажил хийлгэх ял;
 - 1.3. зорчих эрхийг хязгаарлах ял;

1.4. хорих ял;

1.5. эрх хасах ял.

Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг үндсэн ялд хамааруулна. Харин торгох, эрх хасах ялыг үндсэн болон нэмэгдэл ялын чанартай хэрэглэж болно.

Ял нь галт зэвсгийн хууль бус эргэлттэй тэмцэх эрх зүйн чухал хэрэглүүр гарцаагүй мөн бөгөөд уг төрлийн гэмт хэргийг үйлдсэний төлөө хүлээлгэх төрийн албадлагын арга хэмжээ гэдэг утгаараа түүнийг оновчтой тогтоох, зөв хэрэглэх асуудал нэн чухал, тулгамдсан зүйл болоод байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20.4 дүгээр зүйл (Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших) гэмт хэргийн ялыг «байлдааны, хууль сахиулах зориулалттай галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар олж авсан, шилжүүлсэн, борлуулсан, тээвэрлэсэн, хадгалсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ» гэж тогтоожээ.

Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх заалтад торгох ялын ойлголтыг дараах байдлаар өгсөн байна:

1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн тусгай ангид заасан торгуулийн нэгж (цаашид «нэгж» гэх)-тэй тэнцүү хэмжээгээр мөнгөн торгууль оногдуулахыг торгох ял гэнэ.

2. Торгох ялын хэмжээ нь дөрвөн зуун тавин нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.

3. Энэ хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.

4. Шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно.

5. Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солино.

6. Нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг торгох ялаар солихгүй.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлд хорих ялын ойлголтыг дараах байдлаар өгсөн байна:

1. Гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад байлгахыг хорих ял гэнэ.

2. Нээлттэй, хаалттай хорих байгууллагын нөхцөлийг хуулиар тогтооно.

3. Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн хүнийг зургаан сараас хорин жил хүртэл хугацаагаар нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад тусгаарлаж хугацаатай хорих ялыг эдлүүлнэ.

Хорих ял бол Монгол Улсын эрүүгийн хуульд заасан үндсэн бөгөөд ялын хамгийн хатуу төрөл юм. Энэ ялын агуулга нь ялтныг олон нийтээс тусгаарлаж, харуул хамгаалалт, тодорхой дэглэм бүхий хорих тусгай байгууллагад эрх чөлөөг нь хасах болон хязгаарлахад оршино.

Проф. С.Жанцан «Хорих ял нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, ялтанд эрхийн хязгаарлалтаар дэмжсэн хатуу цээрлэл амсуулах, ялтаас дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг гаргуулахгүй байх, нийгмийн дотор байгаа зарим тогтворгүй хүмүүст урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлдэг хамгийн өргөн хэрэглэгддэг төрийн албадлагын онцгой төрөл юм»¹ гэж үзсэн байна.

Монголын шүүн таслах ажлын практикт 10 жилийн байдлаар дунджаар нэг жил тутамд гэм буруутай 8000 шахам этгээдэд хорих (баривчлах ялыг оруулан) ял оногдуулж иржээ. Энэ нь нэг жилд нийт ял шийтгүүлэгсдийн 90 шахам хувийг эзэлж байна.

Хорих ялыг хугацааг манай улсын өмнөх эрүүгийн хууль тогтоомжид үндсэн болон тусгай хугацаа хэмээн тогтоож ирсэн нь нэг талаар нийгмийн аюулаар их биш гэмт хэрэгт хорих ялыг болж өгвөл хэрэглэхгүй байх, нөгөө талаар нийгмийн аюулаар их гэмт хэрэгт ялын бодлогыг сулруулахгүй байлгах шинжлэх ухааны үндэслэгээний тусгал юм. Тухайлбал, 1961, 1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд зургаан сараас 10 жил, 2002 оны Эрүүгийн хуулиар хорих ялын үндсэн хугацааг нэгээс арван таван жил байхаар тогтоож байжээ².

¹ Жанцан, С. Ялын тухай сургаал. 198 дахь тал.

² Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. 704 дэх тал.

Харин 2015 оны Эрүүгийн хуулиар хорих ялын хугацааг зургаан сараас хорин жил хүртэл байхаар, хорих ялыг нээлттэй ба хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр заасан.

Хорих ял нь яллагдагчийн эрхийг хатуу чангаар хязгаарлахын сацуу, нийгмийн тодорхой сөрөг үр дагаврыг (нийгэмд харш харьцаа үүсгэх, гэмт орчны дадал зуршилд суралцах, гэр бүлийн материаллаг байдал дордох, салж сарних зэрэг) өөртөө тээж байдгийн хувьд илүү цээрлүүлэх нөлөөтэй. Ийм тул хорих ялыг яллагдагчийг хүмүүжүүлэх, ял шийтгэлийн зорилгыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд л хэрэглэх ёстой юм.

Галт зэвсгийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэл нь Монгол Улсын хууль тогтоомжоор харьцангуй хүнд биш гэж үзэж болохоор байдаг.

Байлдааны, хууль сахиулах зориулалттай галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар олж авсан, шилжүүлсэн, борлуулсан, тээвэрлэсэн, хадгалсан (20.4) гэмт хэрэгт нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар, Байлдааны, хууль сахиулах зориулалттай галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хадгалах, хамгаалах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас их хэмжээний хохирол учруулсан (хохирогч нас барсан бол) (20.6.2) гэмт хэрэгт хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар хуульчилсан байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20.5 дугаар зүйл (Галт зэвсэг хууль бусаар бэлтгэх) гэмт хэргийн ялыг «Галт зэвсэг, түүний бүрдэл хэсгийг хууль бусаар бэлтгэсэн, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар бэлтгэсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ» гэж тогтоожээ.

Мэргэжилтнүүд галт зэвсгийг хууль бусаар бэлтгэх гэмт хэрэг нь нийгмийн хор аюулын хувьд бусад бүрэлдэхүүнээс, тухайлбал, галт зэвсгийг олж авах, шилжүүлэх, борлуулах, тээвэрлэх, хадгалах, илгээх үйлдлүүдээс илүү аюултай болохыг анхааруулж байна. Галт зэвсгийг хууль бусаар бэлтгэх үйлдэл нь энэ төрлийн бусад гэмт хэргийг үйлдэх үүд хаалгыг нээж өгдөг гэж онцлогийг нь тодорхойлжээ. Тийм болохоор Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид галт зэвсгийг хууль бусаар бэлтгэх гэмт хэргийг хүндрүүлэх, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй байлгах,

эдгээрт оногдуулах ялыг ялгамжтай, сонголттой байхаар хуульчлах шаардлагатай гэсэн саналыг бид дэвшүүлж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20.6 дугаар зүйл (Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах) гэмт хэргийн ялыг «байлдааны, хууль сахиулах зориулалттай галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хадгалах, хамгаалах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас их хэмжээний хохирол учруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ» (20.6.1.) гэж заасан.

2.Энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ» (20.6.2.) гэж ялын хэмжээг зааж өгсөн байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлэг (Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг)-т тусгасан Цэргийн эд хөрөнгө, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зарах, үрэгдүүлэх, завших (28.7) гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр; хүндрүүлэх бүрэлдэхүүнд нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр; онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Цэргийн эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх (28.8) гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр; онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ.

Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зорчих (28.9) гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр; хүндрүүлэх бүрэлдэхүүнд хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэг (Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг)-т тусгасан Террорист үйлдэл хийх (29.8) гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэхээр заасан.

Харин Террорист үйлдэлд бэлтгэх (29.9) гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан байна.

Террорист үйлдэл хийх, Террорист үйлдэлд бэлтгэх гэмт үйлдлүүдийн тухайд эдгээр нь нийгэмд учруулах хор аюулаараа асар их байдаг тул ял шийтгэл нь мөн их байгаа юм.

Монгол Улс нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II Протоколд нэгдэж орсон, 2012 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр уг баримт бичгийг соёрхон баталсантай холбогдуулан цаазаар авах ялыг бүрмөсөн халсан билээ. Энэ Протоколын 1 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт «Энэхүү Протоколд нэгдэн орсон аливаа улсын хууль тогтоомжийн хүрээнд хэнийг ч цаазалж үл болно»¹ гэж заажээ. Үүнтэй уялдуулан 2015 онд Эрүүгийн хуульд цаазаар авах ялыг цуцалж, түүний оронд бүх насаар нь хорих ялыг шинээр бий болгосон юм.

Бүх насаар нь хорих ялын агуулга нь хугацаатай хорих ялын нэгэн адил ялтныг олон нийтээс тусгаарлахад оршино. Хорих ялын нэгэн төрөл болсон энэ ялын их хатуу чанга байдал нь нэгдүгээр, ялын хугацаа байхгүй, хоёрдугаарт, ял эдлүүлэх онцгой нөхцлөөр хангагдах байдлаар илэрнэ.

Бүх насаар хорих ял эдэлж буй этгээдийг хаалттай хорих байгууллагын онцгой дэглэмд эдлүүлж, аюулгүй байдлын чангатгасан арга хэмжээ хэрэглэх шаардлага зайлшгүй үүснэ. Монгол Улс яваандаа цаазаар авах ялыг бүрэн цуцлах нь зайлшгүй мучраас түүний бэлтгэл болгож цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд хугацаагүй хорих ялаар солих тухай нэмэлтийг 1993 оны 6 сарын 7-ны өдрийн хуулиар оруулсан юм. Үүнийг акад. С.Нарангэрэл «бүх насаар нь хорих ял» биш гэж үзсэн байна. Хугацаагүй хоригдож буй этгээд гучаас доошгүй жил хорих ял эдэлсний дараа нийгэмд аюулгүй болсон онцгой тохиолдолд түүнийг ялаас чөлөөлөх асуудлыг шүүх шийдвэрлэдэг байсан. 2002 оны Эрүүгийн хууль батлагдсаны дараахан Д.Дэмбэрэлцэрэн «Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн ялын тухай бүлгийн нэг дэвшилттэй заалт нь Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдэд уучлал

¹ Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. 76 дахь тал.

үзүүлсэн тохиолдолд хугацаагүй хорих ялаар сольж байсныг 30 жил болгон өөрчилсөн явдал болно»¹ гэж бичиж байв.

Хэрэв 2002 оны Эрүүгийн хуулиар дурдсан журмыг ийнхүү өөрчлөөгүй бол эдүгээ манай улс бүх насаар нь хорих ялыг эдлүүлэх бүх талын бэлтгэл ажиллагааг хангасан байх бодит боломж байсан юм хэмээн акад. С.Нарангэрэл, проф. Ж.Эрдэнэбулган нар байр сууриа илэрхийлжээ².

¹ Дэмбэрэлцэрэн, Д. Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий анги: өөрчлөлт, шинэчлэлт, эргэцүүлэл.

-УБ., 2002. 231 дэх тал.

² Нарангэрэл, С., Эрдэнэбулган, Ж. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж

(Нэгэн сэдэвт бүтээл). -УБ., 2019. 262 дахь тал.